320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	718,053,200.00	718,053,200.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	897,788,700.00	306,109,275.94
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	306,109,275.94
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	897,788,700.00	0

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	146,874,391.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	238,791,974.01
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	58	58
620001	Удирдах ажилтан	11	11
620002	Гүйцэтгэх ажилтан	24	24
620003	Үйлчлэх ажилтан	2	2
620004	Гэрээт ажилтан	21	21
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	58	58
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	24	24
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4
650010	Гэрээт ажилтан	21	21
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9	9

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,232,362,645.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,232,362,645.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,165,659,012.92
2104	Хангамж, бараа материалын зардал	14,520,535.92
210402	Тээвэр, шатахуун	12,953,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,567,335.92
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	397,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	397,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,150,741,477.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,150,741,477.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,703,633.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,703,633.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	66,703,633.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,232,362,645.92
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,232,362,645.92
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,232,362,645.92

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улиастай сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 20 зорилтын хүрээнд 125 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 97.6 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улиастай сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжтой холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийг шинээр батлан мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод хяналтыг хэрэгжүүлэх нэгж байгуулаагүй, засаг дарга төсөв зарцуулалтад тавих хяналтаа хангалттай хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,654,999.6 мянган төгрөгөөр буюу 41.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	358,916.2	2,232,872.8	1,873,956.6
Авлага	928,736.6	855,965.0	(72,771.6)
Бараа материал	115,651.8	150,102.8	34,451.0
Урьдчилж гарсан зардал	480.6	-	(480.6)
Үндсэн хөрөнгө	2,475,683.1	3,416,059.0	940,375.9
Нийт хөрөнгө	3,879,468.3	6,654,999.6	2,775,531.3
Өр төлбөр	16,242.8	285,508.6	269,265.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,863,225.5	6,369,491.0	2,506,265.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,879,468.3	6,654,999.6	2,775,531.3

Эх сурвалж: Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,232,872.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,873,956.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
			/мянган төгрөгөөр/
Төрийн сангийн харилцах	351,602.3	2,230,131.2	1,878,528.9
Арилжааны банк дахь харилцах	7,313.9	2,741.6	(4,572.3)
Дүн	358,916.2	2,232,872.8	1,873,956.6

Эх сурвалж: Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 1,873,956.6 мянган төгрөгөөр өссөн нь 2022 оны татварын давсан орлогоос сумын ОНХС, ЗДТГ-ын үйл ажиллагаанд төсөв баталж зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх зарим ажил хийгдээгүй үлдэгдлээр үлдсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй..

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 855,965.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 72,771.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
			/мянган төгрөгөөр/
Ажиллагчтай холбогдсон авлага	676.4	1,091.2	414.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	9,501.1	24,183.0	14,681.9
Хувь хүмүүсээс авах авлага	918,559.1	830,690.8	(87,868.3)
Дүн	928,736.6	855,965.0	(72,771.6)

Эх сурвалж: Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Авлага данс өмнөх оны үлдэгдлээс 72,771.6 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоог хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлага данстай холбоотой ЗДТГ, ХХС-д алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Модны суулгац 13,210.0 мянган төгрөгөөр худалдан авсан ч бодитоор байхгүй бараа материалыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй алдааг залруулсан
2. ХХС-н хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэдийн авлагыг тайлант онд бууруулан ажилласан ч мөн урд онуудын авлага барагдаагүй 151,122.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 0.00 мянган төгрөг болж өмнөх оноос 480.6 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5.4 Бараа материал

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 15,102.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,451.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	2,916.6	3,537.1	620.5
Тусгай зориулалтын материал	-	483.0	483.0
Эм боох материал	2,000.0	2,000.0	-
Дуусаагүй үйлдвэрлэл	-	165.0	165.0
Бэлэн бүтээгдэхүүн	916.6	889.1	(27.5)
Хангамжийн материал	112,735.2	146,565.6	33,830.4
Бичиг хэргийн материал	4,498.5	6,297.5	1,799.0
Аж ахуйн материал	91,717.7	97,929.2	6,211.5
Сэлбэг хэрэгсэл	7,476.0	12,813.5	5,337.5
Түлш, шатах тослох материал	2,002.0	8,306.5	6,304.5
Барилгын засварын материал	1,185.0	1,185.0	-
Бусад хангамжийн материал	5,856.0	20,033.9	14,177.9
Мал амьтад	-	-	-
Дүн	115,651.8	150,102.8	34,451.0

Эх сурвалж: Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 34,451.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 326,268.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,740.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал шилжүүлэн авсан, 12,256.5 мянган төгрөгийн бусад бараа материалаар нэмэгдэж, 305,814.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материал данстай холбоотой ЗДТГ-т алдаа, зөрчил гарсан байна. Үүнд:

1. Худалдан авсан 5,000.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг бараа материал дансанд орлогод аваагүй алдааг залруулсан.

ОНХС-д алдаа, зөрчил гарсан байна. Үүнд:

1. Өвс, тэжээл худалдан борлуулсны үнийг ЗДТГ-н нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлдэггүй, хяналтгүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,416,059.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 940,375.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,431,787.6	3,368,593.5	936,805.9
Барилга, байгууламж, орон сууц	1,822,001.1	2,391,083.0	569,081.9
Авто-тээврийн хэрэгсэл	104,923.3	267,828.7	162,905.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	104,324.3	222,935.1	118,610.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	5,453.1	4,260.2	(1,192.9)
Бусад үндсэн хөрөнгө	395,080.8	482,481.5	87,400.7
Ном	5.0	5.0	-
Биет бус хөрөнгө	43,895.5	47,465.5	3,570.0
Программ хангамж	1,872.5	5,442.5	3,570.0
Бусад биет бус хөрөнгө	42,023.0	42,023.0	-
Дүн	2,475,683.1	3,416,059.0	940,375.9

Эх сурвалж: Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 940,375.9 мянган төгрөгөөр өссөн нь 416,177.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 674,706.0 мянган төгрөгийн сумын ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгөөр нэмэгдэж, 6,366.9 мянган төгрөгийн хөрөнгийг актласан, тайлант оны элэгдлийн зардалд 297,485.8 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данстай холбоотой ЗДТГ-т алдаа, зөрчил гарсан байна.

Үүнд:

1. ОНХС-н хөрөнгөөр худалдан авсан 112,685.0 мянган төгрөгийн автобус болон программыг данс бүртгэлд тусгаагүй алдааг аудитын явцад залруулсан.
2. Эрх бүхий байгууллагын шийдвэргүй 119,085.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн 285,508.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 269,265.8 мянган өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	8,481.0	21,742.6	13,261.6
Хувь хүмүүст төлөх өглөг	470.9	-	(470.9)
Байгууллагад төлөх өглөг	7,290.9	263,766.0	256,475.1
Дүн	16,242.8	285,508.6	269,265.8

Эх сурвалж: Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Өглөг дансны эцсийн үлдэгдэл 269,265.8 мянган төгрөг болж өссөн нь тайлант оныг урд онтой харьцуулахад Хот тохижилт үйлчилгээний албанд гарсан 471.0 мянган төгрөгийн хувь хүмүүст өгөх өглөгийг барагдуулсан, 13,261.7 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын, байгууллагад төлөх 251,735.7 мянган төгрөгийн, ЗДТГ-ын 4,739.4 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг зэрэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Өр төлбөр данстай холбоотой ЗДТГ-т алдаа, зөрчил гарсан байна. Үүнд:

1. Байгууллагад төлөх 5,000.0 мянган төгрөгийн бараа материалын өр, төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй алдааг залруулсан.
2. Аймгийн татварын хэлтэс, Амь-Ус трейд ХХК-д тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй урд онуудын 5,915.8 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,369,491 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,506,265.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	930,906.0	930,906.0	-
Хуримтлагдсан үр дүн	2,549,041.4	5,055,382.0	2,506,340.6
Өмнөх үеийн үр дүн	16,890,988.3	2,549,116.5	(14,341,871.8)
Тайлант үеийн үр дүн	(14,341,946.9)	2,506,265.5	16,848,212.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	383,278.1	383,203.0	(75.1)
Дүн	3,863,225.5	6,369,491.0	2,506,265.5

Эх сурвалж: Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

ТТЗ нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагч нар тус тусдаа төсвийн төслийг боловсруулан ТЕЗ-ийн холбогдох хэлтэст нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 39 дүгээр тогтоолоор ТТЗ-ийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 3,633,887.8 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 2,316,719.5 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 578,137.6 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, 2,420,171.7 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 635,578.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 718,053.2 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс Улсын төсөвт байгууллагуудад олгох тогтмол зардлыг 1,894,782.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Харин сумын ИТХ нь 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, батлаагүй байна.

Гүйцэтгэлээр аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 718,053.2 мянган төгрөгийн, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 1,894,782.8 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 2,420,171.7 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлого 306,109.3 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 639,499.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 212,123.0 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нөлөөлж байна.

Хүснэгт 8. Төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	-	-	-
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	718,053.2	718,053.2	-
3	Татварын болон татварын бус орлого	2,680,114.8	2,420,171.7	(259,943.1)
4	Урьд оны үлдэгдэл	897,788.7	639,499.5	(258,289.2)
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	306,109.3	306,109.3
6	Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал	1,894,782.8	1,894,782.8	-
ДҮН		6,190,739.5	5,978,616.5	(212,123.0)

Татварын болон татварын бус орлогоор 6,763,067.8 мянган төгрөгийг бүрдүүлж татварын буцаан олголтод 419,290.9 мянган төгрөгийг, санхүүжилтэд 6,343,776.9 мянган төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,886,698.9 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээнд зээл олгоогүй, ИТХ, ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	230,146.5	216,183.3	13,963.2	93.9
2	Засаг даргын Тамгын газар	1,338,780.6	1,333,917.3	4,863.3	99.6
3	Орон нутгийн хөгжлийн сан	1,057,083.9	1,026,040.3	31,043.6	97.1
4	Хоршоог хөгжүүлэх сан	400,000.0	201,204.6	198,795.5	50.3
5	Хот тохижилт үйлчилгээний алба	1,269,945.7	1,269,945.7	-	100.0
6	Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал	1,894,817.8	1,839,407.7	55,410.1	97.1
ДҮН		6,190,739.5	5,886,698.9	304,040.6	95.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2023 онд нэмэлт санхүүжилтээр 3,232,362.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 3,165,659.0 мянган төгрөгийг тээвэр шатахуун, дотоод албан томиллолт, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зэрэгт зарцуулж, 66,703.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сумын хэмжээнд тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй бөгөөд сумын хөгжлийн төлөвлөгөөнд улс, аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй "Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-III", "Чадварлаг багш" дэд хөтөлбөр, "Чадварлаг эмч" дэд хөтөлбөр зэрэг арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг тусгасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Улиастай сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/83 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 16,639,682.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 249,595.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 187,196.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төлөвлөгөө гаргаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна. Төсөвт бодит хэмнэлт үүссэн зардал байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгаагдагч байгууллагатай хамааралтай 18 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-н төсвөөс 825.0 мянган төгрөгөөр албан хаагчдад ажлын хувцас худалдан авсан;

ИТХ-н төсвөөс хуралдааны хоолны зардал 1,322.0 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан; "Микс трейвел" ХХК-д 19,620,000 төгрөгийг шилжүүлэн 27 хурлын төлөөлөгч нарыг туршлага солилцох, сургалтад хамруулах нэрээр аялуулан үр дүнгүй, үрэлгэн зардал гаргаж төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчилд тус тус төлбөрийн акт тогтоосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт: Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улиастай сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар харьяа байгууллага, санд хяналтыг хэрэгжүүлээгүй 227,100.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага /хариуцлага тооцох/					
Зөвлөмж	1	227,100.0	1	227,100.0	100
Нийт дүн	1	227,100.0	1	227,100.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 190,583.5 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчил илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчил илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс ахмадын баяр, ахмадын шинэ жилийн арга хэмжээ, номын хэвлэл, телевизийн гэрээний төлбөр, төрийн албан хаагчийн сургалтын төлбөрт 19,461.3 мянган төгрөгийн зардал гаргаж, зориулалт бус зарцуулсан;
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс Засаг даргын Тамгын газрын ажилчдыг БНХАУ-ын Жинин, Хөх хот, бусад хотууд руу аялууулсан 20,000.0 мянган төгрөгийн зориулалт бус, үрэлгэн зардал гаргасан;
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан малчдад хөнгөлөлттэй олгосон өвс, тэжээл худалдан борлуулсны орлогыг төвлөрүүлдэггүй;
4. ХХС-н өмнөх аудитаар өгсөн зарим зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн, зээлийн хугацаа хэтэрсэн 40 зээлдэгчтэй холбоотой 151,122.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг Шүүхийн байгууллагад шилжүүлж, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй;
5. Хот тохижилт үйлчилгээний албанд 2,057,858.3 мянган төгрөгийн албан шаардлага хүргэгдэж, санал дүгнэлт өгөхөөс татгалзсан зэрэг зөрчлүүдэд хяналт тавьж, төсвийг үр ашигтай удирдаж, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй	1	190,583.5					1	190,583.5				
Дүн	1	190,583.5					1	190,583.5				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА


АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ



Огноо: 2024-03-25